

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 6 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот

Г “Прогресскапитал” ХХК-д банк бус санхүүгийн 7  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг  
шинээр олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. ”Прогресскапитал” ХХК-д банк бус санхүүгийн зээлийн, гадаад валютын арилжааны, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвөлгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар олгосугай.

2. Холбогдох хууль тогтоолоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Прогресскапитал ББСБ” ХХК /Т.Туул/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал /-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН